



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/39

Улаанбаатар хот

Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2, 20.2.8 дахь заалт, Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.2 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/36, А/93, дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өндөржүүлсэн бэлэн байдалтай холбогдуулан цус, цусан бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлж, шаардлагатай үед ажиллах ажиллагсдын хуваарь гарган бэлтгэлийг хангуулж ажиллахыг Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч /Ч.Тунгалаг/, Технологийн тасгийн эрхлэгч /Н.Халиун/, Нэгдсэн лабораторийн тасгийн эрхлэгч /М.Цэрэндэжид/-д тус тус үүрэг болгосугай.

2. Болзошгүй гамшиг, осол, хордлого, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ажиллах төлөвлөгөөг мөрдөн, эмнэлгийн яаралтай тусламж, хүний нөөц, багаж тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн мэргэжлийн ангийн нарийн бичгийн дарга /Ч.Далайцэрэн/, Хүний халдварт өвчний дэгдэлтийн үеийн Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн Эрүүл мэндийн сайдын тушаалын хэрэгжилтийг хангаж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Чанар, цусны сонор сэрэмжийн албаны дарга /Т.Алимаа/ нарт тус тус үүрэг болгосугай.

D:\bichig hereg\ALBAN BICHIG\Tushaal\tushaal-2020\A.docx

080233

3. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангахад шаардлагатай хавсралтад заасан хамгаалах хувцас, хэрэгсэл, халдваргүйжүүлэх бодис, төхөөрөмж худалдан авахад шаардагдах хөрөнгийг эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Өнөрзул/-д зөвшөөрсүгэй.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБЯАР

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2020 оны сарын-ний өдрийн
..... дугаар тушаалын хавсралт



**КОРОНАВИРУСТ ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХАД ШААРДЛАГАТАЙ ХАМГААЛАХ ХУВЦАС
ХЭРЭГСЭЛ, ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ БОДИС, ТӨХӨӨРӨМЖИЙН ТӨСӨВ**

№	Шаардагдах материал	Хэмжих нэгж	Тоо, ширхэг	Нэгж үнэ төгрөг	Нийт үнэ төгрөг
1	Нэг удаагийн амны хаалт	ш	15,000	200	3,000,000
2	N95 шүүлтүүртэй амны хаалт	ш	100	3500	350,000
3	Нэг удаагийн халаад	ш	500	3500	1,750,000
4	Гар халдваргүйжүүлэх бодис –Aniosgel	5л	15	92,500	1,387,500
5	Гадаргуу халдваргүйжүүлэх бодис –Surfanios premium	5л	3	155,000	465,000
6	ULV хүйтэн мананцар үүсгэгч төхөөрөмж /ариутгал, халдваргүйтгэл/	ш	1	950,000	950,000
Нийт үнэ					7,902,500